

**“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН БАТАЛГАА, ТҮҮНД ХИЙСЭН
ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ”**

**"LEGAL SAFEGUARDS FOR JUDICIAL ENFORCEMENT AND POLICE
OFFICERS: A COMPARATIVE STUDY"**



Ч.Дашням

ДХИС-ийн харьяа “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийн ШШГАТ-ийн ахлах багш, хошууч.

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон цагдаагийн байгууллагууд нь төрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг ижил чиг үүргийн байгууллагууд юм. Эдгээр байгууллагуудын алба хаагчдын эрх зүйн байдал, тэр дундаа эдлэх баталгааг харьцуулан судалж, дүгнэлт хийснээр энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, байгууллагуудын хүний нөөцийн бодлогод эергээр нөлөөлөх болно.

Сүүлийн 2 жилд Монгол Улсын Засгийн газраас ижил чиг үүргийн байгууллагуудын алба хаагчдын цалингийн шатлалыг тэнцвэржүүлэх бодлого хэрэгжүүлж байгаа явдал нь эдгээр байгууллагуудын алба хаагчдын эрх зүйн байдлыг сайжруулах, хүний нөөцийн оновчтой бодлого хэрэгжүүлэх чухал алхам болж байна. Тийм ч учраас зөвхөн цалин хөлс гэлтгүй эдлэх баталгаа болон бусад эрх зүйн байдлыг адилтган авч үзэж, хууль тогтоомжид тусган хэрэгжилтийг хангах нь байгууллагуудын төдийгүй улс орны аюулгүй байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт ихээхэн эерэг нөлөөлөл үзүүлэх болно.

Abstract: Court decision agency and police agencies are the same functional organizations that carry out specialized functions of the state. By comparing the legal status of the employees of these organizations, including the guarantees they enjoy, and making conclusions, it will attract the attention of academics who conduct research in this field, and will positively affect the human resources policy of the organizations.

In the last two years, the Government of Mongolia has been implementing a policy to balance the salary scale of the employees of the organizations with the same functions, which is an important step in improving the legal status of the employees of these organizations and implementing an optimal human resource policy. That is why not only

the salary, but also the guarantee of enjoyment and other legal statuses are considered equally, and implementation is reflected in the laws and regulations.

Түлхүүр үгс: Алба хаагчдын эрх зүйн байдал, баталгаа, хууль зүйн баталгаа, улс төрийн баталгаа, нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаа.

Key words: Officers legal status, guarantee, legal guarantee, political assurance, social security, economic security.

УДИРТГАЛ

Төрийн алба “тогтвортой байх”¹⁰⁴ зарчим бол төрийн албаны үзэл баримтлалын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үүнийг төрийн алба хаагч тухайн албан тушаал, ажлын байрандаа хэрхэн тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, үнэнч ажиллаж буй байдлаар нь хэмжин тодорхойлж болох юм. Төрийн алба хаагч, тэр дундаа төрийн тусгай алба хаагчдын ажлын байрны тогтвор суурьшилтай, найдвартай байдлыг хангах нь төрийн үүрэг бөгөөд тэдний эрх зүйн байдал буюу эдлэх эрхийн статус (байр суурь) нь үүнийг илэрхийлж байдаг.

Төрийн алба хаагчийн эрх зүйн байдлын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь тухайн албан тушаалын баталгаа буюу эдлэх ёстой эрх нь хэрхэн хуульчлагдсан тухай агуулга юм. Төрийн өндөр албан тушаалд үүнийг “эрх ямба” хэмээн тодорхойлсон нь ч бий. Төрийн алба хаагчийн баталгаа нь алба хаагч тухайн албан тушаалд хэрхэн тогтвор суурьшилтай, сэтгэл ханамжтай ажиллах вэ? гэдэг асуулттай шууд хамааралтайгаар тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл алба хаагчийн баталгаа хэдий чинээ сайн хуульчлагдаж, хангагдсан байна алба хаагч төдий чинээ сэтгэл ханамжийг ажлаасаа мэдэрч, тогтвор суурьшилтай, өндөр үр бүтээлтэй ажилладаг гэж үзэж болно. Нэг үгээр хэлбэл ажилтныг “хөдөлгөгч хүч” гэж нэрлэж болох юм. Цалин хөлс ч үүнд хамаарна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”¹⁰⁵ хэмээн заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага /цаашид ШШГБ гэх/-ын алба хаагчдын эрх зүйн байдал, баталгааг Төрийн албаны тухай¹⁰⁶, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай¹⁰⁷, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай¹⁰⁸, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай¹⁰⁹ хуулиуд болон эдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан журмуудаар зохицуулагдсан байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2022 оны нэмэлт өөрчлөлтөөр “ШШГБ нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн

¹⁰⁴ Төрийн албаны тухай хууль. 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт

¹⁰⁵ Монгол Улсын Үндсэн хууль. 46 дугаар зүйл

¹⁰⁶ Төрийн албаны тухай хууль. 2017

¹⁰⁷ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2016

¹⁰⁸ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. 1994

¹⁰⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017

хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн¹¹⁰” хэмээн тодорхойлсон явдал нь энэ байгууллагын алба хаагчдыг бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх эрх зүйн байдалтай болсныг илэрхийлдэг.

Харин цагдаагийн байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдал, баталгаа нь Төрийн албаны тухай¹¹¹, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай¹¹², Цагдаагийн албаны тухай¹¹³ хуулиуд болон эдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан журмуудаар зохицуулагддаг. “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн¹¹⁴” хэмээн хуульд заасан нь энэ байгууллагын чиг үүрэг, алба хаагчдын эрх зүйн байдал төрийн цэргийн байгууллагаас зарим талаараа ялгаатай гэдгийг илэрхийлж байна.

Мөн алба хаагчдын баталгааны нэгэн бүрэлдэхүүн хэсэг нь “хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах”¹¹⁵ эрхээ эдлэх явдал бөгөөд “ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон эрх, үүрэг”¹¹⁶-ийг хуульчилж өгсөн.

ҮНДСЭН ХЭСЭГ

Энэхүү илтгэлд ШШГ болон цагдаагийн байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдал, баталгааг харьцуулан судлах болсон үндэслэл нь дараах хэд хэдэн шалтгаантай. Үүнд:

1. Аль аль нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын статустайгаар үйл ажиллагаа явуулдаг. /аль аль нь төрийн тусгай албанд хамаардаг/
2. Төстэй чиг үүрэг бүхий байгууллагууд.
3. Олон судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлд эдгээр 2 байгууллагын үйл ажиллагааг харьцуулан судалж, жишээ татсан баримтууд байдаг.

Тийм ч учраас эдгээр байгууллагуудын алба хаагчдын эрх зүйн байдал, тэр дундаа албаны баталгааг харьцуулан судалж үзэх нь зүйтэй юм. ШШГ болон цагдаагийн байгууллагын алба хаагч нь төрийн жинхэнэ алба хаагчид хамаарах

¹¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 257 дугаар зүйлийн 257.1 дэх заалт

¹¹¹ Төрийн албаны тухай хууль. 2017

¹¹² Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. 1994

¹¹³ Цагдаагийн албаны тухай хууль. 2017

¹¹⁴ Цагдаагийн албаны тухай хууль. 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт

¹¹⁵ Монгол Улсын Үндсэн хууль. 16 дугаар зүйл

¹¹⁶ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. 18 дугаар зүйл

тул тэдний хангагдах нийтлэг баталгааг Төрийн албаны тухай хуулийн 61, 62 дугаар зүйлд хуульчилсан. Тухайлбал:

- албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;
- албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах
- гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах;
- албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах;
- орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;
- Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;
- төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах;
- үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх;
- холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа гэх мэт.

Эдгээрээс гадна Төрийн жинхэнэ албан хаагч дараах нэмэлт баталгаагаар хангагдана хэмээн заасан. Үүнд:

- Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөхгүй, халагдахгүй байх;
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх, төрийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч өөрчлөгдөх нь төрийн албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;
- төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан, эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаалын

тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан шалгаруулж авах;

- төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлгийг тухайн байгууллагаас олгох зэрэг болно.

ШШГБ-ын алба хаагчийн эдлэх баталгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 283-288 дугаар зүйлд, цагдаагийн алба хаагчийн эдлэх баталгааг Цагдаагийн албаны тухай хуулийн 83-89 дүгээр зүйлд тус тус хуульчилсан. Дээр дурдсанчлан Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна эдгээр 2 байгууллагын алба хаагчдын баталгаануудыг харьцуулан дурдвал:

Улс төрийн баталгаа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллагын алба хаагчдын улс төрийн баталгааг холбогдох хуулиудад дараах байдлаар хуульчилжээ. Эдгээр нь:

- Алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.
- алба хаагчийг хуульд заасан албан үүргээс нь гадуур улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.
- алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.
- алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглахыг хориглоно.
- алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.

Дээрх улс төрийн баталгаануудыг эдгээр 2 байгууллагын алба хаагчид аль аль нь эдлэхээр заасан. Энэ нь тэднийг аливаа улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, улс төрийн ямар ч өөрчлөлтийн үед тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн байдаг. Ийнхүү тогтвортой байж гэмээ нь эдгээр албадын үндсэн үүрэг болох улс орны дотоод аюулгүй байдлыг сахин хамгаалах чиг үүрэг нь биелэгддэг ач холбогдолтой билээ.

Хууль зүйн баталгаа: Алба хаагчдын хууль зүйн баталгааг салбарын хуулиудад дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Иргэн, албан тушаалтан хэн боловч алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.
- Алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй.
- Алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай адилтган тооцно.
- Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг байгууллага хариуцна.
- Байгууллагын алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.
- Алба хаагчийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу тавьсан шаардлагыг иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан, заавал биелүүлэх бөгөөд биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Эдгээр хууль зүйн баталгааг 2 байгууллагын алба хаагчид аль аль нь эдлэхээр хуульчилсан бол цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаагийн алба хаагч нь дараах хууль зүйн баталгааг нэмэлтээр эдэлдгээрээ ШШГБ-ын алба хаагчаас ялгаатай байна. Тухайлбал:

- Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс учирсан хохирлыг төр хариуцна.
- Дотоод хяналт-аюулгүй байдлын алба хаагчийг тус нэгжийн даргад мэдэгдэхгүйгээр томилох, өөрчлөх, чөлөөлөхийг хориглоно.
- Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас шалгасан, баривчилсан, цагдан хорьсон, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийсэн бол шууд удирдах даргад нь даруй мэдэгдэнэ.

- Тайван цагт цагдаагийн алба хааж байгаа иргэнийг цэргийн жинхэнэ албанд татахаас чөлөөлөх бөгөөд цагдаагийн албанд 2-оос дээш жил ажилласан бол цэргийн албыг биеэр хаасанд тооцно.
- Цэргийн жинхэнэ алба хаагаагүй 18-25 насны цагдаагийн алба хаагчид цэргийн бэлтгэл эзэмшүүлэх үүргийг цагдаагийн төв байгууллага хүлээх ба цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөрийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаар батлуулж, мөрдөнө.
- Хуульд зааснаас бусад үндэслэлээр цагдаагийн алба хаагчийг ажлаас чөлөөлөх, халах, өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

Алба хаагчийн хууль зүйн баталгаа нь албан үүргээ хуулийн хүрээнд итгэл төгс гүйцэтгэх найдвартай ар тал болж байдаг бөгөөд өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааны баталгаа болдгоороо ихээхэн ач холбогдолтой.

Хуулийн дээрх заалтуудаас харьцуулан судалж үзвэл:

- Цагдаагийн байгууллагын алба хаагчийн албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс учирсан хохирлыг төр хариуцахаар хуульчилсан бол ШШГБ-ын алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс учирсан хохирлыг хэн хариуцах вэ? гэдэг нь тодорхой бус байна. Хэдийгээр “хууль зүйн баталгаа” хэсэгт алба хаагч өөрөө хариуцахгүйгээр зохицуулсан боловч хэн хариуцах нь тодорхой бус байгаа нь эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна.
- Мөн ШШГБ-ын алба хаагч тус байгууллагад ажилласан хугацааг цэргийн алба хааснаар тооцох эсэх асуудал тодорхой бус байгаа нь тус байгууллагад ажиллаж байгаад тодорхой шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөж байгаа зарим алба хаагчдын хувьд тодорхой бус байдал үүсгэж байгаа нь ажиглагдаж байна.

Нийгмийн баталгаа: Хуульд зааснаар алба хаагчдын нийгмийн баталгаа нь:

- Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно. Энэ зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно:

- хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;
- хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;
- хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.
- алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

Харин цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаагийн алба хаагчдын ажлын онцлогт нийцүүлэн дараах хэд хэдэн нэмэлт баталгааг хуульчилж өгсөн нь:

- Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.
- Цагдаагийн алба хаагчид эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэг бүхий тусгай зориулалтын эмнэлэг нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, өндөржүүлсэн бэлэн байдал, онц байдал зарласан, хээрийн сургууль, дадлагын үеэр эмнэлгийн баг ажиллуулна.
- Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
- Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлнэ.
- Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагч, эдгээр үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.
- Гэмт хэрэгтэй тэмцэх, дайны болон онц байдал, энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулна зэрэг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар тус байгууллагын алба хаагчийн ажлын онцлогт нийцүүлэн дараах нийгмийн баталгааг тусгайлан хуульчилж өгсөн нь:

- Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон ШШГБ-ын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.
- ШШГБ-ын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.
- Хорих ангийн алба хаагчийг эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай нь холбоотойгоор шаардлагатай бол 1 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах зэрэг болно.

ШШГ болон цагдаагийн байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг харьцуулан судалж үзэхэд зарим ялгаатай байдал харагдаж байгааг дурдвал:

- Ажилласан хугацааг тооцохдоо цагдаагийн алба хаагчийг хаана ажиллаж байгаагаас үл хамааран 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сараар тооцдог бол ШШГБ-ын алба хаагчийн ажилласан жилийг зарим газруудад 1 жил 2 сараар, зарим онцлог газруудад 1 жил 3 сараар ялгамжтай байдлаар тооцдог байна. Мөн ШШГБ-ын аль ч салбарт 1 жил 4 сараар тооцдоггүй болох нь харагдаж байна. Практикаас харахад ШШГБ-д 1 жил 2 сараар тооцогддог газар, нэгжүүдийн ажлын ачаалал нь 1 жил 3 сараар тооцдог газар, нэгжүүдээс илүү ачаалалтай байх тохиолдол түгээмэл байдаг.
- Цагдаагийн байгууллагын алба хаагчийг онцгой нөхцөлд алба хаасантай нь холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулахаар хуульчилсан бол ШШГБ-ын алба хаагчийг 1 сар хүртэл хугацаагаар хамруулахаар ялгамжтай хуульчилсан байна.
- Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх тухай болон албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлэх тухай тус тус хуульчилсан бол ШШГБ-ын алба хаагчийн энэ төрлийн нийгмийн баталгаа хэрхэн хангагдах нь хуульчлагдаагүй /тодорхой бус/ байгаа нь харагдаж байна.

Эдийн засгийн баталгаа: Холбогдох хууль тогтоомжид зааснаар алба хаагчдын эдийн засгийн баталгаа нь:

- Засгийн газар алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.
- Алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно.
- Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор харьяа байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшний зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.
- Байгууллагын захиалгаар гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч цагдаагийн алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.
- Алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:
 1. төрийн тусгай алба хаасан хугацааны;
 2. албан ажлын онцгой нөхцөлийн;
 3. мэргэжлийн зэргийн;
 4. эрдмийн зэрэг, цолны;
 5. хуульд заасан бусад.

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн нэмэлт баталгаа нь:

- Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.
- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

- гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд цагдаагийн байгууллагын захиалгаар суралцаж байгаа сонсогчийн дүрэмт хувцасны болон ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцах зэрэг болно.

Мөн цагдаагийн албаны тухай хуульд “Засгийн газар цагдаагийн алба хаагчийг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ”¹¹⁷ хэмээн заасан нь энэ салбарын алба хаагчдын гэр бүлийн нийгмийн баталгааг дэмжсэн томоохон эрх зүйн орчинд тооцогдох бөгөөд харин ШШГБ-ын хувьд энэ төрлийн агуулга хуульчлагаагүй нь эрх зүйн орчин дутагдалтай болохыг илэрхийлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар ШШГБ-ын алба хаагчийн ажлын онцлогт нийцүүлэн хуульчилсан зарим онцлог баталгаанууд нь:

- Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг ШШГБ-ын алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.
- Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг ШШГБ хүлээнэ.
- ШШГБ-ын алба хаагч хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ажилласан 5 жил тутамд Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдэлнэ.
- ШШГБ-ын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авна.
- Аймаг, сумын Засаг дарга тухайн нутаг дэвсгэр дэх ШШГБ-ын дарга, дэд даргыг албаны орон сууцаар хангах арга хэмжээ авна.
- Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ШШГБ-ын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно зэрэг болно.

ШШГБ болон цагдаагийн байгууллагын алба хаагчдын дээрх баталгаанууд нь хэдийгээр холбогдох хууль тогтоомжуудад тусгалаа олж, эрх зүйн орчин нь бүрдсэн боловч тэдгээрийн зарим нь тунхаглалын шинжтэй буюу амьдралд хэрэгждэггүй болох нь судалгааны үр дүн болон практикийн жишээнүүдээс харагддаг. Тухайлбал: Зарим удирдах албан тушаалд ажиллаж буй алба хаагчид улс төрийн нөлөөлөлтэйгөөр албан тушаалд томилогдох, алба хаагчдыг орон сууцжуулах асуудалд төр хэрхэн дэмжлэг үзүүлэх нь тодорхой бус, олон жилийн

¹¹⁷ Цагдаагийн албаны тухай хууль. 83 дугаар зүйлийн 83.3 дахь заалт.

хугацаанд ажилласан ч орон сууцгүй амьдарсаар байх, онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах гэх мэт. Эдгээр баталгаанууд нь тухайн байгууллагын бодлого, төсөв санхүүжилт, зохион байгуулалтаас шалтгаалдаг учир хэрэгжүүлж эхлэхэд тодорхой хугацаа шаардагддаг. Хэдий тийм ч алба хаагчдын баталгааг хангах хууль, эрх зүйн орчин нэгэнт бүрдсэн тохиолдолд хэрэгжилтийг заалт нэг бүрээр хангаж, хэрэгжүүлж гэмээ нь хүний нөөцийн бодлогын салшгүй нэг хэсэг буюу алба хаагчид тогтвор суурьшилтай ажиллах хөшүүрэг болох ач холбогдолтой юм.

Нөгөө талаас алба хаагчдын баталгааг сайжруулах үүднээс ижил чиг үүрэг бүхий дотоод, гадаадын байгууллагуудын хооронд харьцуулсан судалгаа хийж, тэдгээрийн ололттой талуудыг хууль, эрх зүйн орчиндоо тусган амьдралд хэрэгжүүлэх, алба хаагчдын баталгааг тэнцвэржүүлэх явдал нэн чухал байна. Тийм ч учраас 2024 онд Монгол Улсын Засгийн газраас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын цалингийн зөрүүг харьцуулан дүйцүүлж багасгах алхам хийж хэрэгжүүлсэн нь эдгээр байгууллагуудад ажиллах иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой алхам болсон.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг сахин хамгаалах чиг үүрэг бүхий хууль сахиулах салбарын 2 томоохон төлөөлөл болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллагын алба хаагчдын баталгаа нь эдгээр салбарын үйл ажиллагаа хэрхэн тогтвортой, амжилттай явагдах үйл хэргийн эх үндэс билээ. ШШГ болон цагдаагийн байгууллагын алба хаагчдын баталгаа нь төрийн албаны тухай болон салбарын бусад хуулиудаар тодорхой хуульчлагдсан байдаг. Алба хаагчдын баталгааг улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаа хэмээн бүлэглэн ангилж хуульчилсан бөгөөд энэ нь алба хаагчид аюул, эрсдэлгүй ажлын байранд улс төрийн үйл ажиллагаанаас ангид, эрх зүйт төрийн зарчмаар, эдийн засгийн хувьд хэн нэгнээс хараат бус, гэр бүлээ хэвийн хэмжээнд тэжээн тэтгэх үүргээ гүйцэтгэж гэмээ нь албандаа “үнэнч” зүтгэх утга агуулгатай нийцэж байх ёстойг илэрхийлж байна.

Хэдий тийм боловч “ижил чиг үүрэг бүхий” байгууллагуудын алба хаагчдын зарим баталгаа ялгамжтай байдлаар хуульчлагдсан нь ихээхэн анхаарал татаж байна. Тодруулбал:

- Алба хаагчид онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан шаардлагатай тохиолдолд тодорхой хугацаанд сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах эрх зүйн зохицуулалттай боловч энэ хугацаа нь 2 байгууллагад харилцан адилгүй буюу ШШГБ-ын алба хаагчид 1 сар хүртэл, цагдаагийн алба хаагчид 3 сар хүртэл хугацаанд хэмээн хуульчилсан нь хүний сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээний хугацаанд ялгамжтай хандсан нь харагдаж байна. Энэ нь хэдийгээр байгууллагын

онцлог чиг үүрэгтэй холбоотой боловч тооцоо судалгаа дутмаг байдлаар дүгнэж хуульчилсныг илэрхийлж байна.

- Алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах үүднээс орон сууцаар хангах явдлыг 2 байгууллагад ялгамжтай байдлаар хуульчилсан нь анхаарал татаж байна. Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийг засгийн газраас хэрэгжүүлэхээр хуульчилсан боловч ШШГБ-ын алба хаагчдыг орон сууцжуулах эсэх хууль, эрх зүйн орчин тодорхой бус байна.
- Цагдаагийн байгууллагын алба хаагчийн албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс учирсан хохирлыг төр хариуцахаар хуульчилсан бол ШШГБ-ын алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс учирсан хохирлыг хэн хариуцах вэ? гэдэг нь тодорхой бус байна. Хэдийгээр “хууль зүйн баталгаа” хэсэгт алба хаагч өөрөө хариуцахгүйгээр зохицуулсан боловч хэн хариуцах нь тодорхой бус байна.
- Алба хаагчдын ажилласан хугацааг тооцохдоо цагдаагийн алба хаагчийг хаана ажиллаж байгаагаас үл хамааран 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сараар тооцдог бол ШШГБ-ын алба хаагчийн ажилласан жилийг зарим газруудад 1 жил 2 сараар, зарим онцлог газруудад 1 жил 3 сараар ялгамжтай байдлаар тооцдог байна. Мөн ШШГБ-ын аль ч салбарт 1 жил 4 сараар тооцдоггүй болох нь харагдаж байна. Практикаас харахад ШШГБ-д 1 жил 2 сараар тооцогддог газар, нэгжүүдийн ажлын ачаалал нь 1 жил 3 сараар тооцдог газар, нэгжүүдээс илүү ачаалалтай байх тохиолдол түгээмэл байдаг. Нөгөө талаас хоногийн харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй ШШГБ-ын алба хаагчдын сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндийн асуудлууд нь ажлын ачааллын “хүнд” нөхцөлд тооцогдохуйц байдлаар сөрөг үр дагавруудыг бий болгож байгааг шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан хүлээн зөвшөөрч, анхаарал хандуулах цаг нэгэнт болсныг олон ч судалгаа илэрхийлдэг.
- Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх тухай болон албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлэх тухай тус тус хуульчилсан бол ШШГБ-ын алба хаагчийн энэ төрлийн нийгмийн баталгаа хэрхэн хангагдах нь хуульчлагдаагүй /тодорхой бус/ байгаа нь харагдаж байна.

2024 онд Монгол Улсын Засгийн газраас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын цалингийн зөрүүг харьцуулан дүйцүүлж багасгах алхам хийж хэрэгжүүлсэн нь эдгээр байгууллагуудад ажиллах иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой алхам болсон. Цаашид эдгээр

байгууллагуудын алба хаагчдын бусад баталгааг харьцуулан тэнцвэржүүлэх явдал нэн чухал бөгөөд энэ нь хэдийгээр байгууллагын онцлог, чиг үүргээс хамаарах зүйл боловч алба хаагчдын ажлын ачаалал, эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөлөл зэрэг олон хүчин зүйлсийг нь харгалзан үзэж төрийн тусгай албанд ажиллах илүү ая тухтай нөхцөл, баталгаагаар хангах явдал нь төрийн албаны “тогтвортой” байх зарчимд нийцсэн хүний нөөцийн үр дүнтэй бодлого болж хэрэгжинэ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Төрийн албаны тухай хууль. 2017
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. 2008
4. Цагдаагийн албаны тухай хууль. 2017
5. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2016
6. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. 1994
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017

Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn
2. www.cd.gov.mn
3. www.police.gov.mn

---o0o---